



ХОЛИМОГ ТУЛААНЫ СОНИРХОГЧДЫН ТЭМЦЭЭНИЙ НЭГДСЭН ДҮРЭМ

2021 ОНЫ 1 ДҮГЭЭР САРААС ХҮЧИН ТӨГӨЛДӨР МӨРДӨНӨ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Сонирхогчийн Холимог Тулааны [ММА] тэмцээн нь тус спортыг шинээр сонирхон хичээллэж буй оролцогчдыг цаашид ММА-н спортдоо карьер үүсгэн хөгжиж урагшлахад хэрэгтэй дадлага туршлагыг олгоно.

Тамирчдыг бэлтгэл сургуулилт хийж, энд дурдагдсан дүрэм журмын дагуу өрсөлдөхөд шаардагдах туршлага мэдлэгийг хуримтлуулахад хэрэгтэй хамгийн аюулгүй орчин нөхцлийг бүрдүүлэхэд сонирхогчийн ММА-н үндсэн зарчим оршино.

Олон Улсын Холимог Тулааны Холбоо [ОУХТХ] нь улс орнуудын хууль тогтоомж харилцан адилгүй байдгийг хүлээн зөвшөөрдөг учир гишүүн орнуудад гаргасан баримт бичиг, дүрэм журмын багц нь орон бүрийн хууль эрх зүйн онцлогийг тусгасан байж болно.

Жил бүрийн ОУХТХ-ны сонирхогчийн ММА-н Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн нь өөр өөр оронд зохион байгуулагдаж болох ба хаана болохыг урьдчилан товлож мэдээлэл хүргүүлнэ.

Бидний зорилго бол тулаанчдын аюулгүй байдлыг дээд зэргээр хангахын зэрэгцээ сонирхогчийн түвшний холимог тулааны спортыг нэгтгэсэн, харагдах байдлаараа нийтлэг, ижил төрхтэй болгох явдал юм.

Тамирчдын аюулгүй байдлыг дээд зэргээр хангахын зэрэгцээ сонирхогчийн холимог тулааны спортыг нэгдсэн нийтлэг дүр төрхтэй болгохыг бид зорин ажиллаж байна.

2. ТОДОРХОЙЛОЛТ

“Холимог тулааны спорт” гэдэг нь энэхүү Нэгдсэн Дүрмийн дагуу граплинг, өшиглөх, цохих зэрэг тулааны урлагийн өөр өөр төрлүүдийн техникүүдийг хослуулан ашиглаж өрсөлддөг тулааны спортын төрөл юм.

3. ЭРХИЙН ХҮРЭЭ

Октагоны шүүгч нь тухайн тулааны цорын ганц арбитр байна. Холимог тулааны спортын бүхий л тэмцээн, шоу нь зохион байгуулах хорооны хяналт, удирдлага дор явагдана.

4. ТУЛААНЫ ҮЕ

ОУХТХ-ны дүрмээр явагдаж буй тулаан бүр 3 [гурав] минутаар 3 [гурав] үе үргэлжилнэ. Үе хоорондын амрах хугацаа 1 [нэг] минут байна.

5. ТУЛААНЫГ ЗОГСООХ

Тэмцээний үеэр зөвхөн октагоны шүүгч болон ерөнхий эмч октагон / тулааны бүс рүү нэвтрэх эрхтэй. Шүүгч нь тулааны цорын ганц арбитр ба тулааныг зогсоох эрх зөвхөн түүнд байна.

6. ХАЖУУГИЙН ШҮҮГЧ

Бүх тулааныг хажуугийн 3 шүүгч дүгнэж, оноо өгнө.

7. АРВАН (10) ОНООНЫ СИСТЕМ

Тулааны онооны систем нь 10 онооны систем байна.

8. САНУУЛГА

Зөвхөн дараах үйлдлүүдийг гаргасан тохиолдолд нэг удаагийн сануулга өгнө:

- 1) Торноос барих, зуурах
- 2) Өрсөлдөгчийн шорт, бээлий, шилбэний хамгаалалт, цамцнаас зуурах
- 3) Гарын хуруунуудаа тэнийлгэн өрсөлдөгчийн нүүр лүү чичих

9. ЗӨРЧИЛ

Холимог тулааны тэмцээний үеэр дараах үйлдлүүдийг зөрчилд тооцно.

1. Өрсөлдөгч рүү толгойгоороо тулах
2. Өрсөлдөгчийн нүд рүү хуруугаа хийх
3. Өрсөлдөгчөө хазах болон нулимах
4. Өрсөлдөгчийн ам, хамар, чих рүү хуруугаа хийн зулгааж татах
5. Өрсөлдөгчийн үснээс зулгаах
6. Өрсөлдөгчөө дээш өргөн толгой эсвэл хүзүүгээр нь унагах (pile-driving)
7. Өрсөлдөгчийн сээр нуруу (ахар сүүл багтана) болон дагз руу цохих
8. Хоолой руу хийх бүх төрлийн цохилт болон мөгөөрсөн хоолойноос барьж авах
9. Гарын хуруунуудаа тэнийлгэн өрсөлдөгчийн нүүр, нүд лүү чичих
10. Тохойгоор доош шулуун цохих (12-6)
11. Цавь руу хийх бүх төрлийн цохилт
12. Газар унасан өрсөлдөгчийн толгой руу өшиглөх болон өвдөглөх
13. Газар унасан өрсөлдөгчийн дээрээс дэвсэх
14. Өрсөлдөгчийн бээлий, шорт, шилбэний хамгаалалт болон цамцнаас барьж зуурах
15. Торноос хөл эсвэл гарын хуруугаар барих зуурах
16. Хөл болон гарын хурууний үеийг нугалах мушгих
17. Өрсөлдөгчөө октагон /тулааны бүсээс шидэж гаргах
18. Өрсөлдөгчийн бие дэх ямар нэгэн нүх, шарх руу санаатайгаар хуруугаа хийх
19. Өрсөлдөгчийн биеийн арьсийг маажих, чимхэх, мушгих

20. Тулалдахаас зугтаж зайлсхийх, шүдний хамгаалалтыг санаатайгаар давтан унагах, бэртсэн дүр үзүүлэх
21. Окагон /тулааны бүсэд зохисгүй үг хэллэг хэрэглэх
22. Шүүгчийн зааврыг үл тоож эсэргүүцэх
23. Өрсөлдөгчөө бэртээж болохуйц спортын бус үйлдэл гаргах
24. Үеийн төгсгөлийн хонх дуугарсны дараа өрсөлдөгч рүү довтлох
25. Завсарлагааны үеэр өрсөлдөгч рүү довтлох
27. Тамирчны булангийн дасгалжуулагчдаас тулаанд ямар нэгэн саад учруулах
28. Өөрт давуу байдал үүсгэхийн тулд толгой эсвэл биедээ ямар нэгэн гадны бодис түрхэх

10. ХОРИОТОЙ ТЕХНИКУУД

Дээр дурдсан зөрчлүүдээс гадна Сонирхогчийн холимог тулааны тэмцээнд доорх техникүүдийг хориглоно.

- 1) Тохой болон шууны бүх төрлийн цохилтууд
- 2) Өсгийнд өчих / Heel Hook
- 3) Хүзүү болон нуруу нугасанд ачаалал өгөх бүх төрлийн өчилтүүд (Twister, neck crank, can opener, sit through crucifix гэх мэт)
- 4) Өрсөлдөгчийн толгой руу өвдөглөх

11. ЗӨРЧЛИЙГ ДҮГНЭХ ЖУРАМ

Зөрчил гаргасан эсэхийг зөвхөн октагоны шүүгч дүгнэх эрхтэй бөгөөд октагоны шүүгч зөрчил заагаагүй тохиолдолд хажуугийн шүүгчид дур мэдэн зөрчлийг тооцох эрхгүй.

Хэд хэдэн зөрчлийн нийлбэр эсвэл нэг удаагийн ноцтой зөрчил гаргасан тамирчны тэмцээнд оролцох эрхийг хасна.

Хэрэв тамирчин оноо хасахуйц хэмжээний зөрчил гаргасан бол октагоны шүүгч оноо хасаж байгааг мэдэгдэн дохио өгч хажуугийн 3 шүүгч болон онооны шүүгч тэмдэглэж авна.

Дүрмийн бус зөрчилд өртсөн тамирчинд бэртэл гэмтлийн илэрхий шинж тэмдэг илэрвэл октагоны шүүгч дохио өгч цагийг зогсооно.

Зөрчилд өртсөн тамирчин 5 хүртэлх минутын сэргэлтийн хугацаа авч болно. Гэхдээ энэ нь бүх зөрчилд хамаарахгүй.

- 1) Октагоны шүүгч цагийг зогсооно.
- 2) Зөрчилд өртсөн тамирчны эрүүл мэнд, аюулгүй байдлыг октагоны шүүгч шалгана.

3) Зөрчил гаргасан тамирчныг октагоны шүүгч дундын бүс рүү очихыг зааварлаад гаргасан зөрчлийг ноцтой гэж дүгнэвэл оноо хасаж байгааг хажуугийн болон онооны шүүгчдэд дохио өгч мэдэгдэнэ.

Тулаан хэвтээ байрлалд үргэлжилж байх үед доор байгаа тамирчин зөрчил гаргавал дээр байгаа тамирчин бэртэж гэмтээгүй тохиолдолд октагоны шүүгч тулааныг зогсоолгүйгээр үргэлжлүүлнэ.

1) Октагоны шүүгч доор байгаа тамирчинд гаргасан алдааг нь хэлж мэдэгдэнэ.

2) Үе дууссаны дараа октагоны шүүгч зөрчлийг дүгнээд хоёр тамирчин, хажуугийн шүүгч болон онооны шүүгчид гаргасан шийдвэрээ мэдэгдэнэ.

12. ДҮРМИЙН ХҮРЭЭНИЙ ЦОХИЛТ БОЛОН ЗӨРЧЛӨӨС ҮҮДСЭН БЭРТЭЛ

Дүрмийн хүрээний цохилт: Дүрмийн хүрээний цохилтоос болж бэртсэн тамирчин тулааныг үргэлжлүүлэх боломжгүй болсон бол бэртсэн тамирчин ТКО буюу техникийн нокаутаар ялагдах хүлээнэ.

Зөрчил. Санаатай:

1) Хэрэв бэртэл нь тулааныг шууд зогсоох хэмжээний ноцтой бол бэртэл учруулсан тамирчны тэмцээнд оролцох эрхийг хасаж ялалт эсрэг талын тамирчинд очно.

2) Хэрэв бэртэл авсан тамирчин тулааныг үргэлжлүүлэхийг зөвшөөрвөл октагоны шүүгч тэмцээний зохион байгуулагчдад үүнийг мэдэгдэж зөрчил гаргасан тамирчнаас 2 оноо хасна. Бэртэл учруулах хэмжээний ноцтой зөрчлийг санаатай гаргасан бол заавал 2 оноо хасагдана.

3) Хэрэв дээр дурдагдсан бэртлээс (b) болж тулаан дараагийн үеүдийн аль нэгэнд зогсвол бэртэл авсан тамирчин нь оноогоор өрсөлдөгчөөсөө илүү учир Техникийн шийдвэрээр ялалт байгуулна.

4) Хэрэв дээр дурдагдсан бэртлээс (b) болж тулаан дараагийн үеүдийн аль нэгэнд зогсвол бэртэл авсан тамирчин оноогоор дутуу эсвэл өрсөлдөгчтэйгөө тэнцүү байсан ч тулаан Техникийн тэнцээгээр өндөрлөнө.

5) Хэрэв тамирчин санаатай зөрчил гаргах гэж байгаад өөрийгөө бэртээвэл октагоны шүүгч түүний талд ямар нэгэн шийдвэр гаргахгүй. Тус бэртэл нь дүрмийн хүрээний цохилтын үеэр авсан бэртэлтэй ижилд тооцогдоно.

Зөрчил. Санамсаргүй:

1) Хэрэв бэртэл нь тулааныг шууд зогсоох хэмжээний ноцтой бол дараах тохиолдлуудад октагоны шүүгч No contest буюу Тулаан байхгүй хэмээн зарлана.

a. 3 үетэй тулааны 2 үе нь дуусахаас өмнө тулаан зогссон бол.

b. 5 үетэй тулааны 3 үе нь дуусахаас өмнө тулаан зогссон бол.

2) Хэрэв бэртэл нь тулааныг шууд зогсоох хэмжээний ноцтой бол дараах тохиолдлуудад октагоны шүүгч тулааныг зогсоох үед оноогоор илүү байсан тамирчинд ялалтыг Техникийн шийдвэрээр өгнө.

а. 3 үетэй тулааны 2 үе нь дууссаны дараа тулаан зогссон бол.

б. 5 үетэй тулааны 3 үе нь дууссаны дараа тулаан зогссон бол.

3) Дээрх бэртэл (b) тохиолдсон үед дуусаагүй үеийн оноог дүгнэхгүй.

4) Дээрх бэртэл (b) тохиолдсон үед октагоны шүүгч хоёр тамирчны аль нэгийг торговол эцсийн онооноос торгуулийн оноо нь хасагдаж тооцогдоно.

13. ЖИНГИЙН АНГИЛАЛ

Тэмцээн зохион байгуулагчдын зүгээс өөрөөр батлаагүй бол ОУХТХ-ны албан ёсны тэмцээнүүд нь дараах жингийн ангиллуудаар явагдана.

ЗАЛУУЧУУД, НАСАНД ХҮРЭГЧИД - ЭРЭГТЭЙ	
52.2 кг (115 lbs)	Strawweight
56.7 кг (125 lbs)	Flyweight
61.2 кг (135 lbs)	Bantamweight
65.8 кг (145 lbs)	Featherweight
70.3 кг (155 lbs)	Lightweight
74.8 кг (165 lbs)	Super Lightweight
79.4 кг (175 lbs)	Super Welterweight
83.9 кг (185 lbs)	Middleweight
88.4 кг (195 lbs)	Super Middleweight
93 кг (205 lbs)	Light Heavyweight
97 кг (215 lbs)	Heavyweight
+97 кг (+215 lbs)	Super Heavyweight

ЗАЛУУЧУУД, НАСАНД ХҮРЭГЧИД - ЭМЭГТЭЙ	
47.6 кг (105 lbs)	Atomweight
52.2 кг (115 lbs)	Strawweight
56.7 кг (125 lbs)	Flyweight
61.2 кг (135 lbs)	Bantamweight
65.8 кг (145 lbs)	Featherweight
70.3 кг (155 lbs)	Lightweight
74.8 кг (165 lbs)	Super Lightweight
79.4 кг (175 lbs)	Super Welterweight

Тэмцээнд оролцож буй тамирчид нь тулалдах өдөр бүрийнхээ өглөө жингээ үзүүлнэ.

14. ЭРҮҮЛ МЭНДИЙН ШААРДЛАГА

Бүх тамирчид тэмцээн зохион байгуулагчдын зүгээс гаргасан удирдамжид заасны дагуу тэмцээний өмнөх эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд заавал хамрагдсан байна.

Тэмцээний өмнөх техникийн зөвлөгөөн, жингийн үзлэг болон бусад үйл ажиллагааг тэмцээн зохион байгуулагчид хариуцан явуулна.

Тулааны дараах эрүүл мэндийн үзлэг:

- 1) Тулаан болгоны дараа тамирчид эрүүл мэндийн үзлэгт заавал орно. Эрүүл мэндийн үзлэгийг тэмцээн зохион байгуулагчдын зүгээс баталсан албан ёсны эмч нар хийнэ.
- 2) Тулааны дараах эрүүл мэндийн үзлэгт орохоос татгалзсан тамирчдын тэмцээнд оролцох эрхийг тэмцээний ерөнхий эмчийн шийдвэрээр тодорхой хугацаанд түдгэлзүүлж болно.

15. ХУВЦАС ХЭРЭГЛЭЛ

ОУХТХ-ны албан ёсны тэмцээнд оролцож байгаа тамирчид хувцас хэрэглэлийн талаарх дүрэм журмыг дагаж мөрдөх үүрэгтэй. Тамирчид ОУХТХ-гоор баталгаажсан хувцас хэрэглэл өмсөж байгаа эсэхийг тухайн тамирчдын Үндэсний холбоод хянах үүрэгтэй.

ОУХТХ-ны албан ёсны тэмцээний туршид тамирчид нь ОУХТХ-гоор баталгаажсан хувцас хэрэглэлийг заавал өмсөх үүрэгтэй.

Тэмцээний үеэр тамирчид нь улаан болон хөх өнгийн хоёр иж бүрдлийг ээлжлэн өмсөнө. Иж бүрдэлд: шорт, подволк, бээлий, шилбэний хамгаалалт багтана. Тамирчид нь мөн

шүдний болон эмзэг эрхтний хамгаалалтыг бэлдсэн байна. Тамирчид нь тэмцээнийг дуустал иж бүрдлээ хадгалах үүрэгтэй.